

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН
“МОНГОЛ ХҮН-2020” МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**



Улаанбаатар хот
2016 он

Ардчилсан Намын ҮЗХ-ны 2016 оны
4 дүгээр сарын 18-ны өдрийн 46
дугаар хурлын 05 тоот тогтоолын
хавсралт

СЫН
ГЫН ГАЗАР

**УИХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ҮЗЭЛ САНААНД ТУЛГУУРЛАСАН
НИЙГМИЙН ХӨГЖИЛД МОНГОЛЫН АРД ТҮМНИЙГ АНХЛАН УРИАЛАН ДУУДСАН
УЛС ТӨРИЙН ХҮЧНҮҮДИЙН НЭГДЭЛ БОЛОХ АРДЧИЛСАН НАМ:

- Үндэсний эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх эрхэм зорилгоо нотлон;
- Хүний жам ёсны, заяагдмал эрх, хувийн өмч, төрийн хязгаарлагдмал оролцоо, төрийн нээлттэй, иргэдэд хянагдах тогтолцоо, иргэний нээлттэй нийгэм, жендерийн тэгш байдал зэрэг Ардчилсан Намын тулгуур үнэт зүйлсийг шалгуур болгон;
- “Монгол хүн-2020” хөтөлбөрийн хүрээнд Ардчилсан Намын гишүүд, дэмжигчид, олон нийтийн санал санаачлагад тулгуурлан;
- “Сонгуулийн тухай хууль”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-д нийцүүлэн;
- Монгол төрийн бодлогын залгамж чанарыг эрхэмлэн

**УИХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРӨӨ
СОНГОГЧ ТАНД ТОЛИЛУУЛЖ БАЙНА.**

НЭГ. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН

Хүн амын үндсэн хэрэгцээг тогтвортой хангахуйц, өөрийгөө тэтгэх чадвар бүхий олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төсөв, санхүү мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь макро эдийн засгийн хүрээний гол зорилт мөн.

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН

УХА0122

ЭДИЙН ЗАСАГ

НИЙТЭЭРЭЭ ЧИНЭЭЛЭГ, ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ БҮХИЙ ЭКСПОРТЛОГЧ ОРОН БОЛНО.

Эдийн засгийн хөгжлийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.

- Үйлдвэржилтийг орон даяар эрчимтэй өрнүүлж, ЭКСПОРТЫГ ЭН ТЭРГҮҮНД тавина. Эдийн засгийн бүтцийг шинэчлэн олон тулгууртай болгож, 2020 онд уул уурхайн бус экспортын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, 2 тэрбум ам.долларт хүргэнэ.
- Эдийн засаг дахь бүтээмжийн менежментийг шинэчлэх замаар нийт ажил эрхлэгчдийн ОРЛОГЫГ 2 ДАХИН нэмэгдүүлнэ.
- Хөгжлийн зүтгэх хүч болсон БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ дэмжиж, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
- Макро эдийн засгийн “шинэ тэнцвэрийг” ханган, эдийн засгийн өсөлт урт хугацаанд тогтвортой, нийт иргэдэд хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Инфляцийг нам, тогтвортой түвшинд хадгалж, иргэдийн бодит орлогыг хамгаална.
- Улсын нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгаж, төсөв, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хуримтлалын сангуудыг иж бүрнээр нь бүрдүүлж хөрөнгөжүүлэх бодлого баримтална.
- Эдийн засгийн гадаад тэнцвэртэй байдлыг хангаж, гадаад валютын орох урсгалыг тогтвортой сайжруулан, төлбөрийн нийт тэнцлийг алдагдалгүй байлгана.
- Нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг тууштай дэмжиж нэмэгдүүлнэ.
- Мэдлэг, технологийн дэвшил, инноваци шингэсэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжин, өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Төсвийн төвлөрлийг бууруулж, орон нутагт төсвийн эрх мэдэл олгож, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн гадаад худалдааг олон тулгууртай болгоно.
- Бусад улс орнуудтай хийсэн давхар татварын гэрээнүүдийг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгоно.

- Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 10 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.
- Эрдэнэс МГЛ ХК-ийг олон төрлийн эрдэс, баялагт түшиглэсэн, зах зээлийн эрсдлийг жигд хуваарилсан, улс төрөөс хамааралгүй бизнес төвтэй корпораци болгон хөгжүүлж, иргэн бүрт олгогдсон “Эрдэнийн хишиг” үйлдвэр ширхэг хувьцааны үр өгөөжийг бодитой болгоно.
- Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгоно. Гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийн өөрчлөлт хийж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг зохистой түвшинд барина.
- Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлж, чанарыг сайжруулна. Хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан хялбаршуулж гадаад худалдаанд (экспортын) зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулна (ТХҮЗ-2030).
- Шуудан харилцаа, тээвэр ложистикийн салбарт хувьсгал хийнэ. Ази-Европыг холбосон транзит шуудангийн сүлжээг байгуулна. Бүх нийтийн хаягжуулалтыг эрчимжүүлнэ.
- Гадаад худалдаа, экспортын чиглэлд хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих төрийн бие даасан хуулийн этгээд байгуулна.
- Бизнес орчны статистик, тоо баримт, мэдээллээр хангаж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх төрийн үйлчилгээг нэвтрүүлж, хувийн хэвшлийнхэнд бизнесийн оновчтой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлнэ.
- Нийт зээлийн багцын гуравны нэгийн хүүг нэг оронтой тоонд оруулсан амжилтаа бататгаж, бүх төрлийн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, бодлогоо үргэлжлүүлнэ.
- Зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Шинэ бизнес эхлэл (старт-ап), залуучуудын бизнес санаачлагыг дэмжинэ.
- Тендер шалгаруулалтын тогтолцоог үндсээр нь өөрчилж, үнийн өрсөлдөөнийг голлох бус, хугацаа, чанарын үзүүлэлтийг гол болгох аргачлалд шилжинэ. Дунд, урт хугацаат гэрээг боломжтой болгож, үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Төрийн байгууллагууд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлаж, төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг эрхзүйн зохицуулалтаар чангатгана.
- Газрыг эргэлтэнд оруулж, эдийн засгийн үр өгөөжийг нь нэмэгдүүлнэ. Улаанбаатар хотоос гарах, орох төв замыг 4 эгнээ болгон өргөтгөж, зам дагуу дэд бүтэц бүхий шинэ суурьшлын бүс байгуулан иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Үндэсний жижиглэнгийн худалдааны сүлжээг дэмжих замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаална.
- Хоёр хөрш, гурав дахь хөрштэй хийж байгаа гадаад худалдааг өргөжүүлж, улмаар бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Дархан-Уул, Сүхбаатар, Өмнөговь, Ховд аймгуудад стратегийн болон хил дамнасан чөлөөт бүсийг байгуулна.
- Эдийн засгийг олон тулгууртай болгох зорилтын хүрээнд Олон Улсын “Талын зам” төслийг амжилттай хэрэгжүүлэх талаар идэвхтэй ажиллана.
- Эмийн аж үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжиж, холбогдох эрх зүйн орчинг бий болгоно.

МОНГОЛ УЛ
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА012

№ 79
ОН . . . сар

- Генетик нөөц (мал, ургамал, бичил биетэн) болон материал, генетик нөөцтэй холбоотой уламжлалт технологи, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдгээрийг ашигласнаас бий болох үр ашгийг ил тод хуваарилахтай холбоотой эрх зүйн орчныг бий болгоно.
- Бүс нутаг болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дэмжих зорилтын хүрээнд компани, аж ахуйн нэгжүүд нэгдэх, нийлэхтэй холбогдсон эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
- Төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчдын зүгээс аливаа хэлбэрээр аж ахуйн нэгжийн бизнесийн эрх чөлөөнд халдахыг хориглосон хуулийг санаачилан батлуулна.
- Мэргэшсэн инженертэй холбогдсон эрх зүйн орчинг бүрдүүлж, 1000 хүнд ногдох мэргэшсэн инженер, хөгжлийн судлаачдын тоог дундаж хөгжилтэй орнуудын түвшинд хүргэнэ.
- Цахилгаан эрчим хүч, органик хүнсний экспортлогч орон болно. БНХАУ-тай эрчим хүч худалдах, худалдан авахтай холбогдсон ерөнхий хэлэлцээрийг байгуулна.
- Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Эдийн засгийн идэвхтэй газар нутгийн хэмжээг тэлэхийн тулд судалгаанд үндэслэн нутаг дэвсгэрийн төв хэсэгт хоёр дахь хөгжлийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ.
- Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас жижиг дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг чөлөөлөх тухай хуулиудын үйлчлэх хугацааг сунгана.
- Орон нутгийн зах зээлийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгоно.
- Нийслэл, орон нутагт татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.
- Томоохон төсөл, хөрөнгө оруулалтын гэрээ, баримт бичигт дотоодын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг түлхүү нийлүүлэх зарчмыг тусгаж, борлуулалтыг нь дэмжинэ.
- Төрийн байгууллагуудын (сургууль, эмнэлэг, хүчний байгууллагууд гэх мэт) дүрэмт хувцас, цүнх, ширээ, сандлыг үндэсний үйлдвэрлэлээр хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, тендер, төсөл сонгон шалгаруулалтын нөхцөлд зохих өөрчлөлтийг оруулна.
- “ӨРХ БҮР БАЯЛАГ БҮТЭЭГЧ” үндэсний хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.


АЖ ҮЙЛДВЭР

МОНГОЛЧУУД МОНГОЛДОО БҮТЭЭНЭ

Аж үйлдвэрийн хөгжлийн суурийг тавьсан өнгөрсөн жилүүдийн ололт амжилтаа бататган, Монгол Улсаа үйлдвэрлэлийн эрин үед хөгжүүлэх, бодлого, стратегийг эрх зүйн орчин, суурь аж үйлдвэр, хөнгөн ба хүнсний үйлдвэр, хөрөнгө оруулалт ба экспорт, технологи ба инноваци, хүний нөөц гэсэн зургаан тулгуурт бодлогоор тодорхойлж байна.

- Монгол Улсын аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах, салбарын бүтцийг олон тулгуурт болгох, өндөр технологи, нано-технологийн инновацийн бодлогоор тэтгэх эрх зүйн орчинг бий болгоно.
- Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зорилготой тусгай сангуудын зарцуулалт, орлогын бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад мэргэжлийн холбоод, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.
- Нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гааль, тарифын механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ангиллыг оновчтой тодорхойлж, баялаг бүтээгчдийн бодит хэрэгцээнд үндэслэн төрөөс зорилтот дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.
- Үйлдвэрлэл, технологийн парк, шинжлэх ухаан технологийн парк, хүнд аж үйлдвэрийн цогцолборуудын эрх зүйн орчинг шинэчлэн, эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн инженерийн дэд бүтэцтэй цогц хэлбэрээр байгуулна.
- Ган, зэс, нүүрс-хими, нефтийн гэсэн дөрвөн чиглэлийн суурь аж үйлдвэрүүдийг тухайн бүс, аймгийн онцлог, байгалийн нөөцөд тулгуурлан 2020 он хүртэл хугацаанд үе шаттайгаар байгуулна.
- Аймаг сумын онцлог, газар зүй байршил, түүхий эдийн нөөцөд тулгуурлан Монгол Улсын бүх суманд "Нэг сум - Нэг үйлдвэрлэл" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Төрийн худалдан авалтын бодлогыг үндэсний аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний дотоодын зах зээл дэх борлуулалтыг дэмжихэд чиглүүлнэ.
- Баруун бүсийн аймгуудад барилгын материал, цементийн үйлдвэр, нефть боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж дуусгана.
- Говийн бүсийн аймгуудад нүүрс хими, нефть, зэс, төмрийн хүдрийн орд, усны нөөцөд тулгуурлан зохистой байршилд хүнд аж үйлдвэрүүд, тэдгээрт шаардлагатай дэд бүтцийг бүтээн байгуулж дуусгана.
- Зүүн бүсэд нефтийн нөөц, дэд бүтцэд тулгуурлан 300.0 мянган тонн газрын тос боловсруулах үйлдвэрийг дэд бүтцийн хамт 2020 онд барьж ашиглалтад оруулна.
- Машин, механизм, тээврийн хэрэгсэл, уул уурхай, хөдөө аж ахуй, зам, барилгын тоног төхөөрөмж, бусад төрлийн метал хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг кластерын зарчимд тулгуурлан хөгжүүлнэ.
- Машин, механизмын угсралт, үйлдвэрлэлийг татварын, урт хугацааны гэрээний бодлогоор дэмжиж хөгжүүлнэ.
- Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд жилд 2,3 сая тонн газрын тос боловсруулах, 120.0 мян.тн зэсийн цэвэршүүлэх үйлдвэрийг 2020 онд барьж ашиглалтад оруулна.

- Дархан-Сэлэнгийн бүсэд жилд 500 мянган тонн шууд ангижруулсан төмөр, 350 мянган тонн ган үйлдвэрлэх хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж 2020 онд ашиглалтад оруулна.
- Орхон аймагт жилд 100 мянган тонн ширэм, 100 мянган тонн металл хийц үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг 2020 онд барьж ашиглалтад оруулна.
- Сайншандад жилд 3 сая тонн хүртэл хүчин чадалтай нүүрс-химийн үйлдвэр барьж ашиглалтад оруулах ажлыг эхлүүлнэ.
- Говийн бүсийн аймгуудад нар, салхины эрчим хүчний цахилгааны станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар байгуулна.
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлж, орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөнө.
- Монгол улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.
- Цахим засгийг хөгжүүлнэ.
- Төрийн бизнес процессийн ре-инженеринг хийнэ.
- Төрийн үйлчилгээг дотоодын мэдээлэл технологийн компаниудад тулгуурлан үзүүлнэ.
- Төв, хангайн бүсийн аймгуудын газарзүйн онцлог, байгалийн нөөц, дэд бүтцийн нөхцөл, зах зээлийн багтаамжид нийцүүлэн тохирох байршилд хөнгөн ба хүнсний үйлдвэрүүдийг хөгжүүлнэ.
- Сум хөгжүүлэх сангийн үр өгөөжийг дээшлүүлнэ. Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 800 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй болгоно. Үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн хэмжээг 200.0 тэрбум төгрөгт хүргэж экспортын үйлдвэрлэлийг дэмжих бодлого гаргана.
- Уул уурхайн бус үйлдвэрлэлийн экспортыг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулах хууль, эрхзүйн орчинг бий болгоно.
- Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлж батлан даалтад хамрагдах бололцоог өргөтгөх хүрээнд батлан даалтыг 2 тэрбум төгрөг хүртэл, эргэн төлөлтийг 5 жил болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- Шинээр бизнесээ эхэлж буй иргэнд зориулан гарааны санхүүжилт, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлнэ. Бодлогын хүрээнд зээлийн батлан даалтын сангаар дамжуулж урт хугацаатай, бага хүүтэй үйлдвэрийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болгоно.
- Үндэсний үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилгоор худалдааны нэг цонхны бодлого хэрэгжүүлж, төрөөс экспортын худалдааны компаниудыг дэмжинэ.
- Боловсруулах үйлдвэрлэлийн нийт экспортод эзлэх хувийг 15 хувьд хүргэж, арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэнэ.
- Орон нутагт "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк"-уудыг байгуулах ажлыг эрчимжүүлж, олон улсын стандартын шаардлага хангасан, экспортын чиг баримжаатай экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Мал аж ахуй, фермерийн бүс нутаг, аймгуудыг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг бодлогоор дэмжинэ.



- Барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн цемент, төмөр хийц, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.
- Байнгын ажиллагаатай хилийн боомтууд, олон улсын нисэх буудлыг түшиглэсэн чөлөөт бүсүүдийн төлөвлөлт, дэд бүтцийг байгуулж дуусган, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөжүүлнэ. ^{САН} ~~ТҮН ГАЗАР~~
- Төр, шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжиж, өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нийт аж үйлдвэрийн экспортын 2.5 хувьд хүргэнэ.
- Нано-технологи, био-технологи өндөр технологи нэвтрүүлж, нутагшуулсан болон инноваци шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг татвар, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжинэ. ²⁷ өдөр
- Дэвшилтэт техник, өндөр технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Үйлдвэрлэлийн технологид сэргээгдэх эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологийн хэрэглээг урамшуулна.
- Үндэсний инженерүүдийн тэтгэлгийн сан байгуулах эрхзүйн орчинг бүрдүүлнэ.
- Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийн онолын мэдлэг, практик чадварыг танхимын бус орчинд тэтгэх зорилгоор Үйлдвэрийн дадлага хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Гадаадад ажиллаж амьдарч байгаад ирсэн иргэдийн үйлдвэрлэл эрхлэх бүтээлч санал санаачлагыг дэмжих, тэдний мэдлэг туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.
- Аж үйлдвэрийн салбарт мэргэжлээрээ ажиллаж буй иргэдэд тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлнэ. Тогтвортой ажлын байраар хангах асуудлыг үйлдвэржилтийн бодлоготой уялдуулан шийдвэрлэнэ.

УУЛ УУРХАЙ


- Дэлхийн болон бүс нутгийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг цаг хугацааны тухайн төлөв хандлагатай нь нягт уялдуулан судалгааны институт, өндөр мэргэжлийн эрдэмтдийн үнэлгээ, мэдээлэлд тулгуурлан мэдрэмжтэй зөв шийдэж харьцангуй урт хугацаанд тогтвортой байх, цаашид өсөх хандлага бүхий үнэт метал гэж үзэх/алт, мөнгө, цагаан алт, паллади, ириди, роди, румени, осми/, газрын ховор элемент, зэс, шатах ашигт малтмалуудыг эн тэргүүнд эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг хэрэгжүүлэх, экспортын орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэхийг зорино. Эрдэс баялагийн экспортын хуримтлал ФОНД-ыг үүсгэж бий болгоно.
- Эрдэс баялагийн салбарын хүний нөөцийг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд бэлтгэж, дадлагажуулж, салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Стратегийн орд газрууд болох Таван толгойн нүүрсний ордын хүчин чадал, Эрдэнэтийн зэс, молибденийн ордын нөөцийг тус тус нэмэгдүүлж, Асгатын мөнгө, Гацууртын алт, Цагаан суваргын зэсийн ордыг эргэлтэнд оруулж, Оюу толгойн далд уурхайн төслийг амжилттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг орон нутгийн иргэдээс урьдчилан санал авсны үндсэн дээр олгох, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хяналт, бүртгэл, мэдээллийн санг ил тод нээлттэй болгоно.
- Уурхайн үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг олон улсын жишигт хүргэж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулж, нөхөн сэргээлтийн эрсдлийн сангийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгоно. Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь бүрэн хариуцаж гүйцэтгэдэг болгоно.
- Бичил уурхайн эрх зүйн орчинг боловсронгуй болгож, шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулж, хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулна.
- Алтны салбарт бодлогын дэмжлэг үзүүлж, худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх замаар олборлолтыг эрс нэмэгдүүлснээр алт цэвэршүүлэх үйлдвэр барьж байгуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулна.
- Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000-ны масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газарт 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 45 хувьд гүйцэтгэнэ.
- Эрдэс баялагийн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлнэ.
- Ашигт малтмалын ордын үндсэн болон дагалдах эрдсүүдийг иж бүрнээр ялган авах, үйлдвэрийн хаягдал боловсруулах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.

МОНГОЛ У.
ҮНДСЭНИЙ АУДИ
УХА01:
№ 7
2016 он . . . ца

- Ашигласан түлш, цөмийн болон цацраг идэвхит хаягдлыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хадгалах түр байршуулах, булшлах зорилгоор импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Газрын тос, уламжлалт бус газрын тосны шинэ орд илрүүлэх, улсын хил дамнасан газрын тосны хуримтлал бүхий газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлнэ. Газрын тосны салбарт 2030 он хүртэл баримтлах бодлогыг боловсруулна.
- Газрын тосны олборлолтыг жилд 1.7 сая тоннд, экспортын орлогыг 500 тэрбум төгрөгт тус тус хүргэнэ.
- Нүүрсийг баяжуулан чанарыг сайжруулах, хагас болон гүн боловсруулах замаар нүүрс химийн үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина.
- Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, хангамжийг тогтворжуулж, үнийг зохистой түвшинд барина.
- Хийн түлшний хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтад тавигдах стандарт, дүрмийг баталж, иргэдийн аюулгүй байдлыг хангана.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

- “Сайн Малчин” хөтөлбөр хэрэгжүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлээс бүтээгдэхүүн хүртэлх үе шатны санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан банк, үйлдвэр, малчны хамтын ажиллагаа, уялдааг сайжруулан, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, малчны орон нутагтаа ажиллаж, амьдрах нөхцөлийг дээшлүүлнэ.
- Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх, тухайн орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон шилмэл үүлдэр, омог, хэвшлийн малыг өсгөн үржүүлэх зэрэг үйл ажиллагаанд чиглэсэн урамшуулал, эдийн засгийн хөшүүргийг бий болгоно.
- Бэлчээрийн малын ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор малын үүлдэр угсааг сайжруулах, бордох, эрүүлжүүлэх тогтолцоог малчдын бүлэг, хоршоонд тулгуурлан зохион байгуулна.
- Дархан-Уул аймагт баригдаж буй малын удмын сангийн үндэсний цогцолборыг ашиглалтад оруулах, дэвшилтэт техник, технологийг нутагшуулж, сайн чанарын малын гүн хөлдөөсөн үрийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Биокомбинатад иж бүрэн шинэчлэл хийж, малын эм, био бэлдмэлийн үйлдвэр байгуулан малын импортын эм бэлдмэлийг орлох чанартай эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, одоогийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлнэ.
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар мал сүргийн эрүүл мэндийг хамгаалж, эрүүл, аюулгүй хүнс үйлдвэрлэх үндсэн нөхцлийг бүрдүүлнэ.
- Мэдээллийн технологийн дэвшилд тулгуурлан мал сүргийн шилжилт хөдөлгөөн, удам гарваль, ашиг шим, үржил селекци, эрүүл мэндийн болон үйлдвэрлэл, зах зээлийн үндсэн үзүүлэлтийг багтаасан бүртгэл, мэдээллийн нэгдмэл сан бүрдүүлж, шийдвэр гаргахад ашиглах зорилгоор “Цахим малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Газар тариалан бүхий сумдыг түшиглэн малын тэжээлийн үйлдвэр байгуулж, мал бордох, тэжээх, эрүүлжүүлэх аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх замаар махны үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлж, мах махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой хадгалах зорилго бүхий махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.
- Мах, махан бүтээгдэхүүний экспортыг жилд 1 тэрбум ам.долларт хүргэнэ.
- Эрчимжсэн мал аж ахуй, мал бордох, тэжээх аж ахуй болон гахай шувууны аж ахуй эрхэлж буй аж ахуйг дэмжих зээлийн санг 70 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэйгээр байгуулна.
- ХААҮТП-т түшиглэн орон нутагт мах-сүүний хосолмол ашиг шимт үхрийн эрчимжсэн аж ахуй байгуулах ба эрчимжсэн мал аж ахуйд өндөр ашиг шимт үхрийн тоог 100.0 мянган толгойд хүргэнэ.
- Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай бүс, нутгийн хэмжээг одоогийнхоос 2 дахин өсгөнө.
- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн бага ашиглалттай байгаа нөөцийн (дотор мах, дайвар бүтээгдэхүүн, хонь, ямаа, ингэний сүү гэх мэт) боловсруулалтыг нэмэгдүүлнэ.



- Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, өндөг, гахайн өөх, зөгийн бал зэрэг мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хамаарлыг үе шаттай бууруулна.
- Эрчимжсэн МАА-д зориулан малын тэжээлийн үйлдвэр, техник технологи, цэвэр үүлдрийн мал импортлоход гааль, татварын зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.
- Малчин, үйлдвэр, төрийн төлөөлөл бүхий удирдлагын бүтэцтэй, “Монгол мах” брэндийг бий болгон, олон улсад гаргах зорилго бүхий нэг цонхны бодлоготой Монгол мах корпорацийг ажиллуулна.
- Салбарын техник, технологийг сонгохдоо байгальд ээлтэй байх зарчмыг үндсэн шалгуур болгоно.
- Сорт сорилт, үрийн аж ахуйг сэргээн хөгжүүлж, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаажсан сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт тэг болон цомхотгосон технологийг нэвтрүүлэх, түүнд нийцсэн техникийн шинэчлэлд урт хугацаатай, хүү багатай лизингийн үйлчилгээ, дилерийн тогтолцоог бүрдүүлнэ.
- Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлгийн технологи нэвтрүүлэх ажлыг 70 хувьд, усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 65.0 мянган га-д, жилд шаардагдах бордооны хангамжийг 50 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 75 хувьд тус тус хүргэн, тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл, эвдрэлийг сааруулна.
- Бордоо, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, газар тариалангийн зохистой дадлыг бүрэн нэвтрүүлэх, дотооддоо эрдэс болон органик гаралтай бордооны үйлдвэр байгуулж, хангамжийг нэмэгдүүлнэ.
- Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, дотоодын хэрэгцээгээ 100% хангана.
- Мах, төмс, хүнсний ногооны олон улсын стандарт хангасан зоорь, агуулах, лаборатори бүхий тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээг 21 аймаг, голлох сумдын дунд бүсчлэн байгуулна.
- Хүлэмжийн аж ахуйг дэмжих замаар жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг 20 дахин, хүнсний нарийн ногооны үйлдвэрлэлийг 5 дахин нэмэгдүүлж, импортыг орлох чанартай, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- “Чацаргана” хөтөлбөрийг эрчимжүүлж, кластераар хөгжүүлэн чацарганы нийт тариалалтыг 10 мянган га-д хүргэнэ.
- Орон нутагт импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, нутгийн онцлогтой таримлын нэр төрлийг олшруулж, газар зүйн заалттай хүнсний брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжинэ. Алтайн бүс нутагт “Алим”, “Усан үзэм”, Өмнөговь “помидор”, Завханы “улаан сармис”, Ховдын “тарвас”, Дорнодын “гурвалжин будаа” гэх зэргээр цуврал хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих “Хүнс, хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтын сан” байгуулна.
- Малчин өрх бүрийг мэдээлэл, лавлагаа, алсын зайн сургалтыг авах технологийн боломжийг бүрдүүлнэ.
- Хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг хөгжүүлж, Монгол брэндийг сурталчлах, ХАА ба аялал жуулчлалын зохистой холбоог бий болгоно.

- Алслагдсан сум суурин газарт хүрч ажиллах мал төхөөрөх явуулын үйлдвэрийг аймаг бүрт байгуулна.
- “Малын эрсдлийн сан”-г сум бүрт байгуулан сангийн хөрөнгийг бэлчээр хамгаалах, цөлжилтийг бууруулах, хөв цөөрөм бий болгох, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах, малын эрсдлийг бууруулах зэрэг үйл ажиллагаанд зарцуулдаг болгоно. “Хэн ашиглана, тэр хамгаална” зарчмаар ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж, санг удирдах эрхийг орон нутагт өгнө.
- Хадлан, тэжээл бэлтгэх, дарш, ногоон тэжээл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, лизингийн үйлчилгээг хөгжүүлэх зээлийн санг 100 тэрбум төгрөгт хүргэнэ.
- “ХАА-н танхим” мэргэжлийн төрийн бус байгууллага байгуулагдах эрхзүйн орчинг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн, ХАА-н салбарт оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг сайжруулан, мэргэжилтэн сургах байнгын тогтолцоог бий болгоно.
- “Органик хүнс” хөтөлбөр хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, экспортолно.
- Хөдөө аж ахуй, органик хүнсний биотехнологи, нанотехнологи зэрэг өндөр технологийн үйлдвэрлэлд хөнгөлөлттэй зээл олгох ба тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй лизингийн үйлчилгээ нэвтрүүлж, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьд хүргэнэ.
- Аймгуудад буй мах боловсруулах үйлдвэрүүдийг экспортын шаардлага хангах хэмжээнд шинэчлэхэд зориулж махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг 200 тэрбум төгрөгт хүргэх бодлого барина.
- Мал төхөөрөх, мах боловсруулах орчин үеийн үйлдвэрийг 21 аймагт байгуулах, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлж, малыг жилийн турш жигд хүртээмжтэйгээр зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж, экспортын шаардлага хангасан мал бэлтгэлийн тогтолцоог бий болгон, жилд экспортлох махны хэмжээг 180 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.
- Дулааны аргаар боловсруулах махны үйлдвэрийг 21 аймагт байгуулж, бүтээгдэхүүнийг экспортод гаргана.
- Бүтээгдэхүүний нэр төрлийг сайжруулах замаар үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хуурайсүү болон бусад сүүн бүтээгдэхүүний экспортыг бодлогоор дэмжинэ.
- Өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээгээ 100% хангаж, улмаар хуурай өндөг үйлдвэрлэн экспортолно.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркад (ХААҮТП) түшиглэн мах махан бүтээгдэхүүн, цэвэр болон хуурай сүү, цэцгийн тос, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах замаар үйлдвэрийн аргаар боловсруулсан эрүүл, аюулгүй, шинэ хүнсээр хүн амыг жигд, хүртээмжтэй хангах тогтолцоог бүрдүүлнэ.
- ХААҮТП болон мах боловсруулах үйлдвэрүүдэд малчдаас мах, сүү, малын гаралтай түүхий эдийг нийлүүлэх замаар тухайн бүс нутгийн малчдын орлогыг 2-3 дахин нэмэгдүүлнэ.
- Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр бүрэн хангах, олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 35 хувь, сүүний 30 хувийг тус тус үйлдвэрлэлийн аргаар боловсруулах хэмжээнд хүргэнэ.
- Улаанбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Халхголыг түшиглэн хүнсний бүтээгдэхүүний орчин үеийн тээвэр ложистикийн агуулах, сүлжээг байгуулах

МОНГОЛ УЛ
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА012

№ 7

20.16 он 04 сар

замаар, экспорт, импортын хүнсний эрэлт, нийлүүлэлтийн хурдыг нэмэгдүүлж, зардлыг бууруулна.

- Монгол орны хэвтээ тэнхлэгийн авто зам дагуу тээвэр ложистикийн төвүүдийг түшиглэн хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн борлуулах худалдааны төвүүдийг байгуулна.
- Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, хамгаалах зорилгоор төрийн худалдан авалт, гааль, татварын бодлогоор дэмжих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Хүнсний үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хүчин чадал болон экспортын гэрээг үндэслэн экспортын урьдчилгаа санхүүжилт олгох зээлийн дэмжлэгийг 300 тэрбум төгрөгт хүргэх, дотоод, гадаадын санхүүгийн байгууллагад “экспортын баталгаа” гаргах тогтолцоог бий болгоно.
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж, төлөвшүүлнэ.

ХӨДӨЛМӨР

- 2016-2020: Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулна.
- Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмж, ур чадварт суурилсан цалин хөлсний тогтолцоонд шилжинэ.
- Эдийн засгийн өсөлтийн үр шимийг баялаг бүтээгчдэд түлхүү хуваарилж, орлогын тэгш бус байдлыг арилгах замаар нийгмийн дундаж давхаргын хүрээг өргөжүүлнэ. Энэ хүрээнд ДНБ-д эзлэх цалин түүнтэй адилтгах орлогын хувийг нэмэгдүүлнэ.
- Төрийн албан хаагчийн цалинг нэмэхдээ бага цалинтай хэсгийг эхэлж нэмэгдүүлэх зарчим баримталж, ХХДХ-г нэмэгдүүлсэн хувьтай уялдуулна. Ингэхдээ нийтэд зарлахгүйгээр нэмэгдүүлэх зарчмыг үргэлжлүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийн удирдлагыг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийн суурь хууль боловсруулна.
- Мөнгө зээлийн бодлогоор хөдөлмөр эрхлэлтийг хүчтэй нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээг сонгон шалгаруулах, дотоодын гаралтай бараанд давуу эрх олгохдоо ажиллагчдын тоо, ажлын байрны тогтвортой байдлыг харгалзан үздэг болно.
- Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн хүрээнд хот төлөвлөлтөд тулгуурласан уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний бүтээн байгуулалтаар хүн амын суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн зохистой бодлогыг дэмжинэ.
- Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн даатгалыг шинээр бий болгоно.
- Ажилд авах, ажлын байран дээрх бүх төрлийн ялгаварлалыг зогсоох эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг сайжруулна. Энэ хүрээнд ажил олгогчдын тухайн ажлын байран дээр тавих ерөнхий болон тусгай шаардлагыг хууль, тогтоомжид нийцүүлж, хяналтыг сайжруулна.
- Ипотекийн зээлээр дамжуулан барилгын салбарын албан ёсны ажил эрхлэлтийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- Ногоон ажлын байрыг тооцох аргачлалыг бий болгож, үнэлэмжийг нь нэмэгдүүлнэ.
- Бүс, орон нутгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийг орон нутгийнх нь оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг ХАА-н болон бусад нэмүү үнэ цэнэ шингээсэн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихэд түлхүү чиглүүлж, ажиллах хүчний дотоод шилжих хөдөлгөөнийг оновчтой зохицуулна.
- Хүний нөөцийн хөгжлийг дэмжих хууль эрх зүйн орчныг бий болгож, ажил олгогчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар ажлын байрны тогтвортой байдлыг хадгална.
- Мэргэжлийн боловсрол эзэмшсэн буюу МСҮТ-д суралцаж байгаа монгол оюутнуудыг өндөр хөгжилтэй улс орнуудад дадлагажуулж, мэдлэг ур чадварыг нь сайжруулан, нийт 100 мянган дадлагажигчийг хамруулах эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

МОНГОЛ
ҮНДЭСНИЙ АУД
УХАА
№ 7
ОН 04
СБ

- Баялаг бүтээгчдийг хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтаар дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд иргэдийн 6,600 бүлгийг шинээр байгуулан, 50-иас доошгүй хувийг нь нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж болгож, төлөвшүүлэх замаар сум, хороо бүрт 500-аас доошгүй хүний орлогыг нэмэгдүүлэн, нийт 33,000 ажлын байрыг бий болгох эрхзүйн бүрдүүлнэ.
- Цагийн ажил, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, аутсорсинг хэлбэрийн хөдөлмөр эрхлэлт зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэв маягуудыг зохицуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, хүн амын зорилтот бүлэгт чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд:
 - a. Залуусын ажлын байрыг дэмжсэн “Ажилтай төгсөгч” хөтөлбөр;
 - b. Удаан хугацаагаар гэртээ хүүхэд асарч, ажил эрхлээгүй эмэгтэйчүүд, ганц бие эцэг, эхчүүдийг төрийн байгууллага, томоохон аж ахуйн нэгжүүдээс боломжит ажил үйлчилгээг туслан гүйцэтгүүлэх, нийгмийн идэвхитэй амьдралд татан оруулах, ажлын уян хатан нөхцөл бүхий “Цагийн ажил” хөтөлбөр;
 - c. 40-өөс дээш насны, өөрт тохирох ажлаа олж чадахгүй байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, өсвөр хойч залуу үеийнхэнд хөдөлмөрийн хүмүүжил олгох, мэдлэг, туршлагыг өвлүүлэх, ахмад настны орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” төслийг тус тус үргэлжлүүлэн төслийн хамрах хүрээг 2 дахин нэмэгдүүлнэ.
 - d. Залуучуудад малчны мэргэжил олгож, тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэхэд чиглэсэн “Малчны залуу халаа” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлнэ.
 - e. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөө үргэлжлүүлж, тэдний хөдөлмөрлөх эрхийг хангах, хөдөлмөрийн дадал, чадвар олгох, мэргэжил ур чадварыг нь дээшлүүлнэ.
 - f. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн корпораци” бизнес инкубатор төв байгуулна.
- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох төрийн албан хаагчдын ажилласан жилд нь дүйцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг эрх тэгш, ялгаварлалгүй олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний 5 дугаар хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлж, ажил олгогчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар эрсдэл өндөртэй салбаруудад үйлдвэрлэлийн ослыг бууруулна.
- Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэнэ.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, элсэгчдийг ажил олгогчийн гэрээ, захиалга дээр тулгуурлан элсүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ.

- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хичээл-дадлагын баазыг өргөтгөх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суралцагчдын сурах орчинг сайжруулан чадамжид суурилсан сургалтын тогтолцоог төлөвшүүлнэ.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж, суралцагчдын тэтгэлгийг бууруулахгүйгээр суралцагчдын суралцах сонирхолыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн боловсрол нь хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс үндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг үндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлнэ.
- Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлж, багшлах боловсон хүчнийг чадваржуулна.
- Иргэдэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, төгсөгчдийг өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг гурван хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 100.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхийэд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгох.
- ХАА-н салбарын хөрөнгө оруулалтыг 30 хувь буюу 23,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, тус салбарт ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- Төв, суурин газраас хөдөө рүү шилжих иргэдийг санхүү, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж төвлөрлийг сааруулна.
- Орон нутаг дахь бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг дагаж суурьшсан хүн амд төрийн үйлчилгээ үзүүлэх нийгмийн дэд бүтцээр дамжуулж ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Төв зам дагуу болон төвөөс алсад суурьшиж, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, өрхийн аж ахуй эрхлэх иргэд, бизнес эрхлэгчдийг дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дэмжинэ.

МОНГОЛ У.
 ҮНДЭСНИЙ АУДИ
 УХА012.
 № 79
 04 сар

ЗАМ ТЭЭВЭР

ТРАНЗИТ МОНГОЛ

- Монгол Улсын зам, тээврийн салбарын бодлогыг нэгтгэсэн “Тээврийн нэгдсэн хууль”-тай болно.
- “Хоолойн тээврийн тухай хууль” болон Төрөөс хоолойн тээврийг хөгжүүлэх талаар баримтлах бодлоготой болно.
- “Төрөөс логистикийн тээврийн тухай хууль” болон Төрөөс тээврийн логистикийн талаар баримтлах бодлоготой болно.
- Хөшигийн хөндийд төмөр зам, агаарын тээвэр, авто замын ачааны холимог терминал бүхий “Улаанбаатар логистикийн төв” байгуулна.
- Салбарын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, ур чадвар, туршлагатай үндэсний боловсон хүчний нөөцийг бүрдүүлж, мэргэжлийн их дээд сургуулийн хөгжлийг дэмжинэ.
- Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажилд үндэсний компани, үндэсний ажиллах хүчнийг түлхүү оролцуулна.
- Олон улсын жишигт нийцсэн орчин үеийн терминал төвийг Замын-Үүд, Алтанбулаг, Улаанбаатар хотод байгуулах ажлыг эрчимжүүлнэ.
- ОХУ, БНХАУ хооронд авто замын транзит тээврийг дэмжин хөгжүүлж, дамжин өнгөрөх тээврээс олох орлогыг нэмэгдүүлнэ.
- Олон улсын болон улсын чанартай авто зам дагуу 150-200 км тутамд жолооч, зорчигчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн төвүүдийг байгуулна.
- Улаанбаатар хотод тусгай замын автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.
- Азийн авто замын сүлжээний АН-4 коридор Булган боомт-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 249.7 км хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулна.
- Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны тээврийн коридор 4С буюу Баруун-Урт-Бичигт боомт чиглэлийн 277.2 км хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулна.
- Азийн авто замын сүлжээний АН3 коридор Алтанбулаг – Улаанбаатар – Замын-Үүд чиглэлийн 990 км хурдны авто замыг ашиглалтанд оруулна.
- Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Дорнод аймгуудыг нийслэлтэй холбосон 1538,01 км хатуу хучилттай авто замыг барьж дуусгана.
- Аймгийн төвүүдийг нийслэлтэй холбосон хатуу хучилттай зам дагуух сумдыг хатуу хучилттай замаар холбоно.
- Бүх аймагт гудамж төсөл хэрэгжүүлнэ.
- Аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.
- Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.
- Олон улс, улсын чанартай авто зам, гүүрэнд хийх засвар үйлчилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг хангана. Цаашид авто замын арчилгаа, хамгаалалтыг сайжруулж, ашиглалтыг уртасгах бодлого баримтална.
- “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 1 болон 2 дахь үе шатны хүрээнд хэрэгжүүлж буй “Шинэ төмөр зам” төслийн Тавантолгой – Гашуунсухайт, Тавантолгой – Сайншанд – Хөөт – Чойбалсан, Хөөт – Бичигт, Хөөт – Нөмрөг чиглэлийн төмөр замын суурь бүтэц, Эрдэнэт – Овоотын чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын

санхүүжилтийг үе шаттай шийдвэрлэж, төмөр замын дотоодын сүлжээг өргөжүүлнэ. Нийт – 2131.5 км

- Замын-Үүд боомтод логистикийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, ачаа боловсруулах, түгээх, зорчигчдод үйлчлэх сүлжээг хөгжүүлнэ.
- Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамнасан төмөр замын тээврийн корридорын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, “Уян тариф. Хатуу хуваарь. Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэх, Ази-Европ, БНХАУ-ОХУ-ын хоорондын дамжин өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- Улаанбаатар хотын оршин суугчдын аюулгүй байдлыг хангах, амьдрах таатай нөхцөл бүрдүүлэх, Улаанбаатар төмөр замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын баруун урд талаар өнгөрөн гарах “Богдхан” төмөр замын төсөл хэрэгжүүлнэ.
- Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг транзит зорчигчид транзит ачаа тээвэрлэлтийн зангилаа болгон хөгжүүлэх замаар олон улсын томоохон нисэх буудлуудтай холбож, тус нисэх буудлын нутаг дэвсгэрийг оролцуулсан эдийн засгийн чөлөөт бүс байгуулна.
- Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудалд транзит зорчигчдыг ая тухтай хүлээн авах “Чингисийн Монгол” үйлчилгээний төв байгуулна.
- Монгол улсыг БНХАУ-ын томоохон хотууд, аялал жуучлалын бүсүүдийг ОХУ-ын Новосибирск, Красноярск, Омск, Екатеринбург, Эрхүү, Улаан-Үүд зэрэг хил орчмын хотуудтай холбосон транзит үйлчилгээний төв болгоно.
- Буянт-Ухаа дахь “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг арилжааны бус чиглэлээр ерөнхий зориулалтын, төрийн онцгой болон тусгай үүргийн нислэгт ашиглах, агаарын хөлгийн засвар үйлчилгээний бааз, олон улсын нисэхийн сургалт, дадлагын төв болгоно.
- Монгол улсын агаарын навигацийн үйлчилгээний менежментийг сайжруулж, үйлчилгээний орлогыг нэмэгдүүлнэ.
- “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Ази, Европын томоохон зангилаа олон улсын нисэх буудлуудыг холбосон нислэгийг нэмэгдүүлж, Хойд Америк руу шууд нислэг үйлдэнэ.
- Дотоодын агаарын тээвэрлэгчийн орон нутгийн болон олон улсын нислэгийн сүлжээг өргөжүүлж, тийрэлтэт агаарын хөлгөөр парк шинэчлэлт хийнэ.
- 160 гаруй сумдын тогтмол нислэгийг бага оврын онгоцоор сэргээж, “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- Чойбалсан, Ховд, Мөрөнгийн нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгон өргөтгөн шинэчилж, тус нисэх буудлуудыг бүсийн зангилаа болгоно.
- Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгоно.
- БНХАУ-ын хойд, зүүн хойд бүс, ОХУ-ын Алс дорнодын далайн боомтуудыг ашиглан гадаад худалдааны тээвэр хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 79
2018.04.04


ЭРЧИМ ХҮЧ

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМИЙН НАЙДВАРТАЙ, БИЕ ДААСАН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЖ, ЧАНАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАСНААР ИРГЭДИЙНХЭЭ АЯ ТУХТАЙ АЖИЛЛАЖ, АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.

- Эрчим хүчний хэрэгцээний 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангана.
- Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-аар хүргэнэ.
- Эрчим хүчний эрэлт, хэрэглээ, үйлдвэрлэл, борлуулалт, үр ашгийн зохистой харьцааг хангасан стратегийн судалгаа, төлөвлөлт, менежмент бүхий дунд хугацааны үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Эрчим хүчний түлшний аюулгүйн нөөцийг бүрдүүлж, хангамжийг баталгаажуулна.
 - Багануур, Шивээ-Овоо, Шарын голын уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар технологийн шаардлага хангасан түлш бэлтгэж, ашиглагдаж байгаа болон шинээр баригдах цахилгаан станцуудад нийлүүлнэ.
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангах эх үүсвэрийг урьдчилан бий болгоно.
 - Төвийн бүс: Чойр-Нялгын бүсэд 700 МВт, өмнөд хэсэгт 450 МВт-аас доошгүй хүчин чадал бүхий эх үүсвэр ашиглалтад оруулна.
 - Баруун бүс: Увс аймагт 60 МВт-аас доошгүй хүчин чадал бүхий шинэ эх үүсвэр барина. Мөн Ховд гол дээр баригдах УЦС-уудын суурь судалгаа, ТЭЗҮ, БОННУ-г хийнэ. Баян-Өлгий аймаг дахь Ховд голын Тавалтайн хавцалд усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ.
 - Дорнод бүс: Дорнод аймгийн Чойбалсан хотод 50 МВт-аас доошгүй хүчин чадал бүхий эрчим хүчний эх үүсвэрийг байгуулж, уул уурхай, газрын тос олборлох үйлдвэрүүдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангана.
 - Алтай-Улиастай: Алдагдал ихтэй цахилгаан дамжуулах агаарын шугамаар нийлүүлэгдэж байгаа эрчим хүч, үр ашиг муутай дизель станцуудыг орлох 30 МВт-аас доошгүй хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэрийг барина.
- Төвийн эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой ажиллагааг хангах, тохируулгын эх үүсвэрийг барих ажлыг эхлүүлнэ.
 - Энэ ажлын хүрээнд 315 МВт-ын хүчин чадалтай Эгийн голын усан цахилгаан станцын дэд бүтцийн урьдчилсан шатны ажлыг хийж дуусгах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх, Шүрэнгийн УЦС-ын төслийн суурь судалгаа, ТЭЗҮ, БОННУ-г хийж гүйцэтгэнэ.
 - Нүүрс хийжүүлэн эрчим хүч үйлдвэрлэж, хуримтлуулах эх үүсвэр байгуулах техник эдийн засгийн үнэлгээ, судалгаа хийнэ.
- Төвлөрсөн дулаан хангамж, шөнийн бага ачаалалттай үеийн хямд цахилгааныг ашигладаг хэсэгчилсэн дулаан хангамжийн шинэ эх үүсвэрийг бий болгох замаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудын өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангана.
 - Эрдэнэтийн ДЦС-ыг 35 МВт
 - Дархан ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөнө.

- Аймгийн төвүүдийн дулаан хангамжийг сайжруулах хүрээнд дараах аймгуудад дулааны станц, дулааны нэгдсэн шугам сүлжээ байгуулан, дулааны станцын нүүрсний хангамжийг шийдвэрлэнэ. Үүнд:

- Архангай
- Баянхонгор
- Говь-Алтай
- Говьсүмбэр
- Дундговь
- Завхан
- Өвөрхангай
- Хэнтий
- Сүхбаатар
- Төв



- Төв, зүүн, зүүн өмнөд, өмнөд бүсийг нэвтрүүлэх чадвар өндөртэй цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох, дэд станцуудыг барих замаар цахилгаан хангамжийг сайжруулна. Үүнд:

- Улаанбаатар–Багануур
- Багануур-Чойр
- Улаанбаатар-Мандалговь
- Багануур-Чингис
- Чингис-Чойбалсан
- Сайншанд-Замын-Үүд
- Мандалговь-Арвайхээр

- Эрчим хүчний салбарт техник технологийн шинэчлэл хийх замаар алдагдлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэн ухаалаг сүлжээг нэвтрүүлж, хэрэглэгчдэд хүргэх эрчим хүчний хангамжийн үйлчилгээг сайжруулна.

- Улаанбаатар, Багануур-Зүүн өмнөд бүс, Эрдэнэт-Булган, Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах, ашиглалтад буй дулааны цахилгаан станцуудын үр ашгийг дээшлүүлэх, төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээний мэдээлэл, хяналтын тоон системийн хүрээг өргөжүүлэх, дэд станцуудын удирдлагыг тоон системд шилжүүлж, үр ашигтай ухаалаг сүлжээ болгох төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Эрчим хүчний экспортын эх үүсвэртэй болно.

- Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн уурхай, цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам бүхий цахилгаан экспортлох цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа, техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.
- Говийн бүсэд нар, салхины том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбор барьж, Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох төслийн суурь судалгааг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.


- Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 150 МВт чадал бүхий нар, салхины эх үүсвэр шинээр байгуулна.

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ

- “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлнэ.
- Бүх аймгийн төв болон 15,000-аас дээш хүн амтай суурин газрыг ХОТ-ын статустай болгох бодлого баримтлана.
- Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах газар нутаг ашиглалтын мастер төлөвлөгөөг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд тус тус боловсруулах ажлыг эхлүүлнэ.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулна. Ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгоно.
- Улаанбаатар хот, бусад хот, сууринг дахин төлөвлөнө.
- Улаанбаатар хотыг утаагүй болгоно.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүс нутгийн төлөвлөлтийг орон нутаг, иргэдийн оролцоотойгоор олон улсын стандартын дагууд хийж, бүтээн байгуулалтыг бүрэн дуусгана.
- “Шинэ сум-1:2:3” хөтөлбөрийг иргэд, орон нутаг, улсын хамтын оролцоотойгоор үргэлжлүүлж, дуусгана.
- Барилгын салбарт хариуцлагыг чангатгаж, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулж, барилгын талбай орчимд иргэдийн аюулгүй, амар тайван зорчих нөхцлийг бүрдүүлнэ.
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дагуу барилга, байгууламжийн төлөвлөлтийг дунд, урт хугацаанд хийдэг зарчимд шилжинэ.
- Монгол Улсын нөхцөл байдалд нийцсэн хөгжингүй орнуудад хэрэглэгдэж буй олон улсын норм, стандартыг зөвшөөрнө.
- Барилгын шинэ технологи, эко барилгыг Монголд нутагшуулах бодлого бий болгоно.
- Хот, суурин газрын хуучин орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах “Дулаан байр-1:1” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Барилга, хот байгуулалтын салбарт зөвлөх үйлчилгээ, даатгалын шинэ тогтолцоог бий болгоно.
- Хашаа байшинг сайжруулан “Хувийн орон сууц” болгож, ипотекийн зээл, хүүгийн зохистой бодлого нэвтрүүлнэ.
- Барилгын салбарыг улирлын хараат байдлаас гаргах үйлдвэрлэлийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Барилгын хатуу хог хаягдлыг дахин боловсруулах менежментийг сайжруулж, хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна.
- Ипотекийн зээлийг илүү хүртээмжтэй болгох бодлого баримтлана.
- Түрээсийн орон сууцны хөтөлбөрийн хэрэгжих төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.
- “Орон сууцжуулах хөтөлбөр”-ийг иргэдийн оролцоо, амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, ногоон үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Усны үр ашигтай, зохистой хэрэглээг хангах зорилгоор саарал ус ашиглах технологийг дэлгэрүүлнэ.
- Гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулна.

- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.
- Хотуудын усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийж, хангамжийн бие даасан системийг дэмжинэ.



ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- Хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэвээр хадгална.
- Монгол Улсад хүүхдийн эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулна.
- Бүх аймаг, дүүрэг “Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн ордон”-той болсон байна.
- Залуучуудын эрхийн тухай шинэ хуулийг боловсруулан, баталж “Монгол залуу хүн” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Ахмад настны эрхийг хангаж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжсэн эрх зүйн орчинг сайжруулна.
- Ахмад настанд зориулсан бүсчилсэн сэргээн засах, эмчилгээ, сувилгааны цогцолбор төвүүдийг аймаг, нийслэлд байгуулж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- Бүх аймаг, дүүрэгт “Ахмад настны хөгжлийн ордон” байгуулж, өдөр өнжүүлэх, зөвлөгөө өгөх, хөгжүүлэх үйлчилгээг өргөжүүлж, насжилтад бэлтгэж, ахмад настанд зориулсан үйлчилгээг шинэ шатанд гаргана.
- Гэр бүлийг дэмжих эрх зүйн орчинг сайжруулснаар гэр бүлд чиглэсэн үйлчилгээг бий болгож, хэрэгжүүлнэ.
- Гэр бүл, хөдөлмөрийн харилцаа, эрүүл мэнд, боловсрол, улс төр, нийгмийн амьдрал, төрийн албан дахь жендэрээр ялгаварлан гадуурхлыг арилгах, хүйсийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Жендерийн мэдрэмжтэй бодлого боловсруулах, хүйсийн тэгш байдлыг хангасан төсөвлөлт, төлөвлөлтийн арга зүй, чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бий болгоно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвүүдийг нийслэл, орон нутагт байгуулна.
- Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга, байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн өөрчилнө.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэний нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээнд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг болно.
- Тэтгэврийг цалингийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулах бодлого баримтлана.
- Тэтгэврийн шинэчлэлийг эрчимжүүлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлнэ.
- Хувийн тэтгэврийн даатгалыг тэтгэврийн нэмэлт давхарга хэлбэрээр хөгжүүлнэ.
- Гадаад улсад оршин сууж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн хамгааллыг баталгаажуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг байгуулна.
- Ганц бие ахмад настны нийгмийн хамгааллыг баталгаажуулж, хамтын тэтгэвэр олгох хуулийн хэрэгжилтийг хангана.
- Монгол Улсын бүх иргэнд эрүүл мэндийн даатгалын цахим үнэмлэх олгоно.
- Эрүүл мэндийн байгууллагаа даатгуулагч өөрөө сонгох сонголтыг дээдэлж, өрсөлдөөнийг бий болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

- Даатгуулагчийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдлээс хамаарсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд тогтмол хамруулахад анхаарна.
- Нийгмийн даатгалын салбарт мэдээллийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, нийгмийн даатгалын шимтгэл цуглуулах, ажил олгогч даатгуулагчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээлэл өгөх ажлыг бүрэн цахимжуулна.
- Халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийг сонгохдоо улс төрийн болон эрх мэдэлтний нөлөөлөлгүйгээр хүртэх ёстой эзэнд нь хүргэх зорилгоор Монгол Улсын өрх, хүн амын амьжиргааны мэдээллийн нэгдсэн цахим санг үүсгэнэ.
- Нийгмийн халамжийн орлого бүрдүүлэлтэд хувийн хэвшлийн оролцоо, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж, урамшуулал, дэмжлэгийн тогтолцоог бий болгоно.
- Асрамжийн газруудын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.
- Нийгмийн халамжийн хөгжлийн үйлчилгээг ТББ, мэргэжлийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэнэ.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 79
2016 он 04 сар

ХОЁР. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ МОНГОЛ ХҮН

ЭРҮҮЛ МЭНД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАГДСАН МОНГОЛ ХҮН

УРТ НАСЛАЛТАЙ МОНГОЛ ХҮН


- Хамгийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, Монгол хүн эх орондоо дэлхийн түвшний эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлнэ.
- Өндөр өртөгтэй эмчилгээг дэлхийн шилдэг эмч нартай хамтран эх орондоо хийснээр, Монголд эмчлэгдэх боломжгүй өвчин эмгэгийн тоог 70 хувиар бууруулна.
- Гадаадад хийлгэдэг эмчилгээг эх орондоо хийх эмч сувилагчдын багийн үйл ажиллагаа явуулах эдийн засаг, эрх зүйн бүрэн боломжийг бий болгоно.
- Жил бүр 300 их эмч, 600 сувилагчийг гадаадад болон гадаадын эмч, мэргэжилтнийг дагалдуулан сургах нөхцлийг бүрдүүлнэ.
- 2012-2016 онд 11 аймагт оношлогоо эмчилгээний төв байгуулж, хөдөөнөөс хот руу ирэх урсгалыг бууруулсан амжилтаа ахиулан, үлдсэн 10 аймаг, нийслэлийн зарим дүүрэгт байгуулна.
- Иргэдэд шаардлагатай байгаа тусламж үйлчилгээг явуулын эмнэлгээр үзүүлнэ.
- Нисдэг тэрэг, мэргэшсэн баг бүхий алсын дуудлагын цогц үйлчилгээг алслагдсан аймаг, сумын иргэдэд хүргэж, яаралтай тусламжийн хурд, чанарыг илүү нэмэгдүүлнэ.
- Эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлтөнд 25, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөнд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөнд 13 болгож бууруулна.
- Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих "ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ХҮҮХЭД" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, орчныг бий болгоно.
- Монгол анагаах ухаан - Дэлхийн бренд бодлогыг боловсруулан, Монгол Үндэстний анагаахын төв болгон хөгжүүлнэ.
- Монгол анагаах ухааны мэдлэг, уламжлалт эмийг гадаадад экспортлож, гаднаас ирэх валютын урсгалыг нэмэгдүүлнэ.

ЭРҮҮЛ АМЬДРАХ ЗАН ҮЙЛ, ШИНЭЧЛЭЛ

Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, "Бидний эрүүл мэнд-Бидний гарт" гэсэн ойлголт, дадал хэвшлийг иргэдэд бий болгон, эрүүл амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

- "Өвдсөн хойно нь биш өвдөхөөс нь өмнө" бодлогоор халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлогооны зардлыг даатгалаас санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- "Халдварт өвчингүй Монгол хүн", "Эрүүл дадал-Эрсдэлгүй иргэн", "Элэг, зүрхээ Хайрлая", "Хавдаргүй Монгол хүн" зэрэг зорилтот бүлэг рүү чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

- Монгол Улсыг элэгний Ц вирусгүй дэлхийн анхны улс болгох зорилт тавьж ажиллана.
- Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, чадавхийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.
- Товлолт дархлаажуулалтын хамралтыг 98 хувь, 10,000 хүн амд вирус хепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14.4 болгон бууруулна.
- Гэр бүл, орон нутгийн засаг захиргаа, иргэдийн санаачлагаар “ЭРҮҮЛ ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬ, ХОТ, АЙМАГ” болох хөдөлгөөн өрнүүлж, эрүүл мэндээ эмч, эмнэлэгт хариуцуулдаг хэвшмэл сэтгэлгээг өөрчилнө.



ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭШСЭН ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ

Эмнэлгийн байгууллагуудын засаглал, санхүүгийн ил тод бөгөөд удирдлагын бие даасан байдал, гүйцэтгэлд суурилсан зохицуулалт, хариуцлагыг сайжруулан олон улсын түвшинд хөгжүүлэх эрх зүйг бий болгох

- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийг цомхон, чадварлаг бүтцээр зохион байгуулж, гадаадын ижил төстэй эмнэлгүүдтэй өрсөлдөхүйц түвшинд хүргэж хөгжүүлнэ.
- Нэгдсэн эмнэлэг, үндэсний төвүүдийг эрх зүй, эдийн засаг, засаглал, менежментийн хувьд бие даалган, удирдлагыг мэргэшсэн, улс төрөөс хараат бус, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнд ногдох зардлыг 2 дахин нэмэгдүүлж, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийг менежментээр бие даалган ажиллуулна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНОВЧТОЙ САНХҮҮЖИЛТ

Иргэнийг эрүүл мэндээс үүдсэн санхүүгийн эрсдлээс хамгаалсан санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгоно.

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нийт санхүүжилтийн 70-аас доошгүй хувийг санхүүжүүлдэг, бие даасан нэг худалдан авагчийн ҮНДЭСНИЙ ЭМД-ын тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.
- Монголчуудын сайн мэдэх БНСУ, Япон, Тайванийн Эрүүл мэндийн санхүүжилт, даатгалын тогтолцооны шилдэг ололт, амжилтыг нэвтрүүлнэ.
- Даатгалаас хөнгөлөлттэй олгох эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- ЭМД-аас санхүүжих тусламжийн чанарт илүү анхаарч, нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- Хөрөнгө оруулалтыг 2 дахин нэмэгдүүлж, төрөлжсөн эмнэлгүүдийг бүрэн шинэчлэх бодлого баримтлана.
- Үндэсний оношлогоо эмчилгээний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн шинэ эмнэлэг, Сонгинохайрхан дүүргийн жишиг эмнэлгийг ашиглалтанд оруулна.

ЦАХИМ ЭМНЭЛЭГ

Эрүүл Мэндийн цахим хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн мэдээллийг гэрээсээ цаг алдалгүй авах боломжийг иргэдэд олгоно.

- ТҮЦ машинд эрүүл мэндийн мэдээллийг оруулсанаар иргэд эмнэлгийн бүх төрлийн мэдээлэл, магадлагаа, онош, эмчилгээний зөвлөгөөг авдаг болно.
- Зайн оношилгооны сүлжээг өргөтгөснөөр иргэд өрх, сумаасаа оношлогоо, эмчилгээг цаг алдахгүй хийлгэх боломжтой болно.
- Санхүүжилт нь эмнэлгээ биш, иргэнээ дагадаг болгож, эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.
- Эмч мэргэжилтний мэдээллийг цахим болгож, иргэдийн сонголт хийх боломжоор хангана.

ҮНЭ ЦЭНЭТЭЙ МЭРГЭЖИЛТЭН

Эрүүл мэндийн салбарын ажилтны мэдлэг, ур чадварыг олон улсын жишигт хүргэнэ.

- Анагаахын их, дээд сургуулийг мэргэжлийн арга зүйгээр удирдах чиг үүргийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Анагаахын сургууль төгсөгчдийг нэгдсэн, төв эмнэлэгт ажиллуулж, суурь мэдлэг, дадлага эзэмшүүлсний дараа резидентээр сургахад эдийн засгийн хөшүүрэг бий болгоно.
- Эмч мэргэжилтнүүдийн цалинг урьдчилан сэргийлэлт, эдгэрэлт, хяналтын үр дүнгээр тооцож, нийгэм, эдийн засгийн баталгааг эрс сайжруулна.
- Сувилагч, тусгай мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог шинэчлэн, нэг өвчтөнд ноогдох сувилагчийн тоог олон улсын жишигт хүргэнэ.
- Анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэн, өрх, суманд өндөр чадвартай эмч ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн хандлага, мэдлэг, чадвар, ёс зүй, хариуцлагын шалгуурыг сайжруулж, хамтын хариуцлага, даатгалыг нэвтрүүлнэ.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажиллах нөхцөлийг сайжруулан, үнэ цэнэтэй эмнэлгийн мэргэжилтнийг тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ


- Тив дэлхий, олон улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах олон улсын жишгийн битүү цэнгэлдэх хүрээлэн барина.
- Хүүхэд, залуучууд, ахмадын биеийн тамирыг дэмжиж дугуйн, гүйлтийн, уулын, явган хүний зам барьж, усан бассейн, фитнес клубуудыг дэмжиж ажиллана.
- Хувийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан спорт цогцолбор байгуулсан иргэн, аж ахуй нэгж байгууллагыг татварын бодлогоор дэмжинэ.
- Их спортыг дэмжин, спорт клубуудыг амжилтаар нь дэмжих бодлого баримтлана.

ГУРАВ. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ МОНГОЛ ХҮН

МЭДЛЭГТ СУУРИЛСАН НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧАДВАРЛАГ МОНГОЛ ХҮН

БОЛОВСРОЛ

- Монгол хүүхэд нэг бүрийг үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай иргэн болгон төлөвшүүлэх зорилготой “Зөв монгол хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын “Цөм” хөтөлбөрийг үргэлжлүүлж, төр, орон нутаг, иргэний нийгмийн байгууллага, гэр бүлийн оролцоог өргөжүүлнэ.
- Амжилттай хэрэгжиж буй Авьяас, Ном, Багш хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, гэрийн сургалтын хэлбэрээр өргөтгөж, хамран сургалтыг 100%-д хүргэнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 6 настай сурагчийн асрагч багш ажиллуулах эрхзүйн орчинг бүрдүүлнэ.
- 2021 онд ерөнхий боловсролын чанарыг олон улсын чанарын үнэлгээ (Programme for International Student Assessment-PISA)-ээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийг 2 ээлжид бүрэн шилжүүлж, тогтвортой байдлыг хангана.
- Сумын сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг тогтвортой нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Ерөнхий боловсролын сургуульд тусгай хэрэгцээт боловсрол олгох орчин нөхцөлийг бий болгоно.
- Бага ангийн багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг эрс сайжруулна.
- Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүйд тавих шалгуурыг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулна.
- Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Боловсролын салбарын бүртгэл мэдээллийн системийг үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын түвшинд хүргэнэ. (www.ESIS.edu.mn)
- Багш, суралцагчдын хөгжлийг дэмжих сургалтын цахим лаборатори, видео хичээл, е-сурах бичиг, онлайн сургалт, виртуал орчин бүхий сургалтын нээлттэй тогтолцоог дэмжинэ.
- Сайн хичээл, үйл ажиллагааны туршлага солилцох зөвлөгөөнийг багш мэргэжлээ дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих үндсэн арга, тогтолцоо болгон хөгжүүлнэ.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт зал, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилго бүхий барилга байгууламжийг хүн амын нягтаршил, орон нутгийн онцлогтой уялдуулан төлөвлөж, нэмэгдүүлнэ. Барилга байгууламж нь байгальд ээлтэй, эдийн засагт хэмнэлттэй технологи, стандартын шаардлага хангасан байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадлын судалгаанд үндэслэн бага, дунд, ахлах сургуулиудыг бий болгоно.
- Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах, өөрийн хэрэгцээний туслах аж ахуй эрхлэх боломжийг нэмэгдүүлж



стандартын шаардлагад нийцсэн “Үдийн хоол” хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн сургуульд хариуцуулна.

- ЕБС-д ухаалаг самбар бүхий иж бүрэн хэрэгсэл, STEAM (Science, Technology, Engeneering, Arts and Mathematics) лаборатори нийлүүлж, өндөр хурдны интернетэд бүрэн холбоно.
- Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлнэ.
- ЕБС-ийн 50-иас дээш хувьд сурагчдын спортын авьяасыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий хөлбөмбөгийн талбайг байгуулна.

Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн, олон улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлж, тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлнэ. (ТХҮБ-2030)

- Академик мэдлэг ба хэрэглээний чадвар хослосон их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, олон улсын жишигт нийцүүлнэ.
- Дээд боловсролын хөтөлбөрийн чанарыг сайжруулан, олон улсын нэр хүндтэй байгууллагаар магадлан итгэмжлүүлнэ.
- Их дээд сургуульд байгалийн шинжлэх ухаан, инженер технологи, багш мэргэжлээр суралцах оюутныг дэмжиж, эдгээр чиглэлээр элсэгчдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
- Японы “1000 инженер” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Сургалт судалгаанд түшиглэсэн инновацийн, шинэ бүтээгдэхүүн гаргах “Азийн Глобал Коосэн”-ийн төвийг Говьсүмбэр аймагт байгуулж, дэлхийд өрсөлдөх монгол инженерийг бэлтгэнэ.
- Өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд улсын зээлийн хөрөнгөөр болон 2 улсын Засгийн газрын гэрээгээр бакалавр, магистрт суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.
- Дэлхийн шилдэг их дээд сургуулиудад (топ 100) суралцуулах оюутны тоог нэмэгдүүлнэ.
- Орон нутгийн их дээд сургуулиудыг төрийн бодлогоор идэвхтэй дэмжинэ.
- Дэлхийн томоохон их сургуулийн хөтөлбөрөөр академик англи хэлийг богино хугацаанд эрчимтэй сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутны англи хэлний мэдлэгийг сайжруулах чиглэлийн үйл ажиллагааг дэмжинэ.
- “Оюутны сургалтын төлбөрийн зээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.
- Дээд боловсролын сургалтын байгууллагын багш судлаачдын сургалт, эрдэм шинжилгээ, үйлчилгээ, олон нийтийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий чансаа тогтоох үнэлгээний систем бий болгоно.
- Их сургуулиудын хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.
- Энтерпрёнершип, инновацийг хөгжүүлэх зорилгоор АНУ-ын MIT-тай (Массачусетсын технологийн их сургууль) их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын оюутан, судлаач, профессор, энтерпрёнеруудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 2018 онд Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн дэргэд олон улсын жишигт хүрсэн эмнэлэг ашиглалтанд оруулна.

- Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60 хүртэл мянгад хүргэнэ.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ур чадвар олгоход чиглүүлж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчдын тэтгэлгийг бууруулахгүйгээр суралцах сонирхлыг дэмжин, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

ШИНЖЛЭХ УХААН

Шинжлэх ухаан, технологийг монгол улсын тогтвортой хөгжлийг хангах, амьдралын чанар, үндэсний чадамж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацийг дэмжиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засаг бүрэлдэн тогтох нөхцөлийг бий болгоход чиглүүлэн хөгжүүлнэ.

- Шинжлэх ухааны паркт мэдлэг шингэсэн инновацийн бүтээгдэхүүн гаргах, дэлхийн тавцанд хамтран ажиллах нөхцөл боломжийг бий болгоно.
- Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачид хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, брэнд бүтээгдэхүүн бий болгох, зах зээлд гаргах боломжийг бүрдүүлж, татвараас чөлөөлөх эрхзүйн орчинг бүрдүүлнэ. (Старт-апыг дэмжих)
- Уламжлалт мэдлэг ухаанд суурилсан шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлж, судалгааны үр дүнг бүтээгдэхүүн болгоход дэмжлэг үзүүлнэ.
- Органик хүнсний үйлдвэрлэл, экспортыг дэмжинэ.
- Дэлхийн жишигт нийцсэн биотехнологийн үндэсний лаборатори, үйлдвэр байгуулна.
- Монгол судлалыг дэмжих үйл ажиллагааг өргөжүүлж, дотоод гадаадад хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

СОЁЛЫН САЛБАР

Үндэсний соёл урлагийг дэлхий нийтэд сурталчлах, соёлын өвийг уламжлан хадгалах, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр монгол соёлын дэлхийд эзлэх байр суурийг бэхжүүлнэ.

- Монгол соёлын гэгээрүүлэх, эрдэмжүүлэх, хүмүүжүүлэх агуулгуудыг судлан сурталчилж, соёл урлагийн нийгэм-эдийн засаг, хүний хөгжилд үзүүлэх үүргийг нэмэгдүүлж, хууль эрхзүйн таатай орчныг бүрдүүлэн хөгжүүлнэ.
- Үндэсний язгуур соёл-Дэлхийн сонгодог соёл-Орчин цагийн нийлмэл соёлын гурвалсан бодлогыг хэрэгжүүлнэ.
- Монгол үндэстэн угсаатны өв соёлын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.
- Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах нэгдмэл бодлогыг гаргаж, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнэтэй өвийн үйлдвэрлэл хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүн нийлүүлэх кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор “Киноны тухай хууль” батлуулж хэрэгжүүлнэ.
- Сумын соёлын төвийн үйлчилгээг өргөжүүлж, кино театртэй болгоно.
- Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэн эдийн засгийн бодит салбар болгон хөгжүүлнэ.
- Соёл урлагийн зах зээлд зохиогчийн эрх, оюуны өмчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.

ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН

БАТЛАН ХАМГААЛАХ

- Нийт иргэдийн оролцоо, орон нутгийн хамгаалалтанд тулгуурласан батлан хамгаалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- 2015 оны “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн үзэл санааг хэрэгжүүлж, батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
- Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах батлан хамгаалах эдийн засгийн чадавхийг бэхжүүлнэ.
- Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэн, Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг сайжруулж, Эх оронч үндэсний үзэл, хүмүүжил, хүний хөгжил, төлөвшлийн орчинг бүрдүүлнэ.
- Зэвсэгт хүчин үндсэн чиг үүргээ биелүүлж, энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.
- “Зэвсэгт хүчин-2030” хөгжлийн хөтөлбөр, “Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлнэ.
- Цэргийн зэвсэглэл, техник хэрэгслийг шинжлэх ухаан, технологийн хөгжил, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн Зэвсэгт хүчний шаардлагад нийцүүлэн шинэчилнэ.
- Агаарын орон зай, агаарын хилийн хамгаалалтанд тавих хяналтын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн, иргэний нисэхийн байгууллагатай хамтарч ажиллана.
- Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах бүх нийтийн олон хэлбэр, нөхцөлтэй сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- Иргэдийн цэргийн алба хаах сонирхол эрмэлзэлийг нэмэгдүүлэх эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хугацаат цэргийн албан хаагчдад иргэний мэргэжил эзэмшүүлж “Цалинтай цэрэг” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх бодлого баримтлана.
- “Оюутан цэрэг” хөтөлбөрийг хот, хөдөөгийн цэргийн ангийн сургалтын баазыг түшиглэн хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөтгөнө.
- “МСҮТ - Цэргийн алба” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, суралцагчдыг цэргийн алба хаасанд тооцох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- “Монгол цэрэг - бүтээн байгуулалт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Архангай, Говь-Алтай аймгуудад барилга инженерийн цэргийн тусгай салбар байгуулна.
- Батлан хамгаалах, спортын салбарыг хамтад нь хариуцах төрийн захиргааны байгууллага байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Барилга инженерийн цэргийг бэхжүүлнэ.
- Цэргийн албан хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол улс “NOMADIC BY NATURE” нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.

- “ХОТ АЙЛ-ХОТЕЛ” хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрх бүр жуулчин хүлээж авах боломжийг бүрдүүлж, малчид өөрсдөө нүүдлийн соёлын аялал жуулчлалын гол үйлдвэрлэгч байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Олон улсын нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулж, нислэгийн тоог хоёр дахин нэмэгдүүлнэ. Мөрөн, Даланзадгад, Ховд, Чойбалсан хотуудын нисэх онгоцны буудлуудыг олон улсын зэрэглэлтэй болгоно.
- Аялал жуулчлалын авто замд үргэлжлүүлэн хөрөнгө оруулалт хийнэ. Бүх аймгийг хатуу хучилттай замаар Улаанбаатартай холбож, баруун зүүн бүсийн аялал жуулчлалыг эрс нэмэгдүүлнэ.
- Аялал жуулчлал хөгжих боломжтой аймаг, сумдад жижиг онгоц нисгэх дэд бүтэц байгуулна. Томоохон жуулчны баазуудыг жижиг хэмжээний аэродромтой болгоно.
- Байгаль, соёлын өвийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц стандарт бүхий эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэнэ.
- Аялал жуулчлалын ариун цэврийн дэд бүтцийг ачаалал ихтэй байршил, аялал жуулчлалын гол бүс нутаг, замын дагууд бүрэн шийдвэрлэнэ.
- Байгалийн адал явдалт аялал, тусгай сонирхлын аялагчид, морин аялалд үйлчлэн туслах уламжлалт өртөөний соёлыг дэлгэрүүлж, онгон дагшин орчинд аялах аялалын дүрэм мөрдүүлэх замаар энэ төрлийн аялал жуулчлалын даац, хүчин чадлыг эрс нэмэгдүүлнэ.
- Уламжлалт өв, газар нутгийн онцлог шинж чанартай уялдуулан мал аж ахуйн эд хэрэглэгдэхүүнд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг жуулчдад зориулан, таниулах чиглэлээр тусгайлан хөгжүүлнэ.
- Дэлхий дахинд таран суусан Монгол угсаат хүмүүст өлгий нутагтаа ирж үзэх, үндэсний их түүх, соёлоороо бахархах боломжийг олгож, энэ чиглэлийн аялал жуулчлалын бодлого хэрэгжүүлнэ.
- Дэлхийн монголчуудыг Монголын аялал жуулчлалын салбарын нэг чухал зорилтот зах зээл хэмээн үзэж гадаад харилцааны бодлоготой уялдуулан зорилтот бодлого хэрэгжүүлнэ.
- Үндэсний бахархал, түүхэн өв уламжлалаа сэргээн бэхжүүлэх зорилгоор Архангай аймагт Үндэсний оюун санаа, аялал жуулчлалын төв байгуулна.
- Шинэ нисэх онгоцны буудлын чөлөөт бүсийг хөгжүүлж худалдаа, үйлчилгээ, тоглоом, цэнгээний газрын дэд бүтцэд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулна.
- Дамжин өнгөрөх замдаа “Чингисийн Монгол” нүүдлийн соёл иргэншлийн богино хугацаатай аялал жуулчлал хийх боломжийг бүрдүүлнэ.
- Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Хилийн боомт бүхий газруудад хил орчмын иргэд чөлөөтэй зорчих, аялах боломжийг нээж, орон нутагт эрх олгох эрхзүйн орчинг бий болгоно.
- АСЕМ-ийг зохион байгуулсан туршлага дээр үндэслэн Албан хэргийн аялал жуулчлалыг идэвхтэй хөгжүүлнэ. Олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг зохион байгуулах Convention center байгуулахыг дэмжинэ.
- Нийслэлтэй хамтран “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА015

№ 7

2016 он 04

БАЙГАЛЬ ОРЧИН

- Ногоон хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн тулгуур бодлого болгоно.
- Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
- Экосистемийн тэнцвэрт байдал
- Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.
- “ХАМГААЛДАГ НЬ АШИГЛАХ” зарчмаар тухайн орон нутагт амьдарч буй иргэд, малчид байгаль орчноо өөрсдөө хамгаалж, хамгаалсан газрынхаа байгалийн нөөц баялгийг өөрсдөө ашигладаг болно.
- Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог дэмжинэ.
- Байгаль орчны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглахад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- Цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.
- Байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлнэ.
- Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийнэ.
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.
- Хүн амын унд, ахуйн болон бэлчээрийн малын ундны усны эх үүсвэрийг онцгойлон хамгаалах, тэдгээрийг хүнд үйлдвэрлэл, уул уурхайд ашиглуулахгүй байх, Уул уурхайн үйлдвэрлэлд усан хангамжийн найдвартай эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Гадагшаа урсгалтай гол мөрнүүдээс говь, тал хээрийн бүсийг усжуулах, уул уурхайн үйлдвэрлэлд хүргэх төсөл хэрэгжүүлнэ.
- Нийслэлийн ундны усны хангамжийг сайжруулах зорилгоор Туул гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон

хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлнэ.

- Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, ногоон хэрэм байгуулах ажлыг эрчимжүүлж экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална. Ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэнэ.
- Ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгааг иж бүрэн хийж, биологийн аргаар голчлон тэмцэнэ. Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, гамшгийн үед найдвартай ажиллах салбар дундын механизм бүрдүүлнэ. Ойн нөөцийн зүйл бус ашиглалтанд тавих төрийн хяналтыг чангатгаж, үүнд олон нийтийн оролцоог бүхий л хэлбэрээр хөхүүлэн дэмжиж хамтран ажиллана.
- Ойн цэвэрлэгээг эрчимжүүлэх замаар иргэдийн ахуйн хэрэгцээг хангах, импорт орлох модон материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Ойн нөөцийг нэмэгдүүлэх, улсын ойн сан арвижуулах хүрээнд бие даан ургах хүртэлх арчилгааг иж бүрэн хийнэ.
- Хангайн бүс, говийн бүс тус бүрт нэг шилмэл үр, өндөр хүчин чадалтай мод үржүүлгийн аж ахуйг хувийн хэвшлийг дэмжих замаар бий болгоно.
- Устах аюулд орсон амьтан ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх ажлыг эрчимжүүлэх, ховор ба ашигт ургамлыг тарималжуулах, ан амьтныг өсгөн үржүүлэх иргэд, аж ахуйн нэгжийн санаачлага, хөрөнгө оруулалтыг төрийн бодлогоор дэмжинэ.
- Монгол улсын ан агнуурын бүсийг шинэчлэн тогтоож, агнуурын эдэлбэр газрыг хувийн хэвшилд түрээслүүлэх эрхзүйн орчин бүрдүүлж шилжүүлэх замаар хулгайн анг хязгаарлаж, хууль ёсны ан агнуурын үйлчилгээ бий болгоно.
- Бэлчээр хамгаалах, цөлжилтийг бууруулах зорилгоор бэлчээр ашигласны төлбөртэй болгон, уг татварын орлогыг орон нутагт нь хуримтлал үүсгэж, бэлчээрээ хамгаалах, хөв цөөрөм бий болгох, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах зэрэг үйл ажиллагаанд зарцуулдаг болно.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) хэмжээг 25 хувьд хүргэж Удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, бүсчлэн хөгжүүлэх стратеги хөтөлбөр боловсруулах, тодорхой болзол нөхцөлтэйгөөр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудад хариуцуулан ажиллана.
- ТХГН-ийн дэд бүтцийг хөгжүүлж, аялал жуулчлал эрхлэх стандартыг ногоон хөгжлийн зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ.
- Агаарын бохирдлыг бууруулах урт хугацааны зорилт нь орон сууцжуулах хөтөлбөр байх бөгөөд богино хугацаандаа дараах ажлуудыг хийнэ.
- Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөнө. Барилгын дулааны алдагдлыг 25 хувиар бууруулна.
- Байгалийн хий, цахилгаан эрчим хүчээр дулааны асуудлыг шийдвэрлэх технологи нэвтрүүлнэ.
- Агаарын хяналт, шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлнэ. Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах аж ахуйн нэгж, байгууллагын шинэ санал, санаачлага, цэвэр технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд төр тусгай бодлогоор дэмжинэ.

МОНГОЛ УЛСЫН
УРДСГИЙН АУДИТЫН

УДА0122

799

cap

- Улсын хэмжээнд нам даралтын зуухнуудыг татан буулгаж нэгдсэн системд холбоно. Хот, суурин газруудад ногоон байгууламжинд шаардагдах төсвийг нэмэгдүүлнэ.
- Улаанбаатар болон аймгийн төвүүдэд өртөг багатай бүх төрлийн сайжруулсан түлшээр хангах арга хэмжээг хувийн ~~Хөвшилтэй~~ хамтран зохион байгуулна.
- Олон улсын стандартад нийцээгүй, байгаль орчныг бохирдуулж байгаа авто тээврийн болон бусад өөрөө явагч хэрэгслийг Монгол Улс импортлохгүй байх, стандартын шаардлага хангаагүй бүх төрлийн автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх бодлого хэрэгжүүлнэ. Хийн болон цахилгаан авто тээврийн хэрэгслийн цэнэглэх станцын сүлжээ байгуулна.
- Улсын төсвийн хөрөнгөөр байгуулж байгаа бүх барилга байгууламжийг эрчим хүч, дулааны хэмнэлттэй, зөвхөн байгаль орчинд ээлтэй бараа материалаар хийх журмыг мөрдөнө.
- Хот суурин газрын дундуур урсдаг голуудын эргийн тохижилтын ажил хийж, иргэдийн амралт зугаалгын бүс болгон тохижуулна.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлнэ.
- Улаанбаатар хотын болон хөдөө орон нутгийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг өргөтгөж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Стандартын шаардлага хангасан био жорлонг голын эх, хөрсний усны нөөц бүрдэх бүс дэх гэр хорооллын 10,000 айлд байршуулж, усны бохирдлыг хамгаална.
- Хог хаягдлын эх үүсвэрт нь дахин ашиглах боломжтой дахиварыг (шил, лааз, метал, цаас гм) ангилан ялгаж, боловсруулах жижиг дунд үйлдвэрийг дэмжинэ. Хог бий болгосон эх үүсвэрт хариуцлага хүлээлгэх тогтолцоог нэвтрүүлнэ.

ГАДААД ХАРИЛЦАА

- Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг эрс нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нь гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болно.
- Манай улсын иргэд гадаадад, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад визгүй чөлөөтэй зорчих чиглэлд эрс ахиц гаргана.
- Гадаадад оршин суугаа болон түр хугацаагаар зорчиж буй иргэддээ үзүүлэх бүх талын тусламж дэмжлэгийг нэмэгдүүлж, тэдэнд зориулсан консулын цахим үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Гадаадад ажиллаж буй иргэдийнхээ амьдрах, хөдөлмөр эрхлэх нөхцлийг сайжруулах, тэдний байгуулсан сайн дурын холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжих зэргээр тэдний эрх ашгийг бүхий л талаар хамгаална.
- Гадаадад сурч, хөдөлмөрлөж буй иргэд эх орондоо ирж суурьших тохиолдолд тэдэнд ажил, бизнес эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- Улс орноо гадаадад сурталчлах, гадаад дахь монгол угсаатнуудад монгол хэл, түүх, соёл, уламжлалаа сэргээхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, ажиллах хугацааг нь уртасгах, түр хугацаагаар нээгддэг боомтуудыг байнгын ажиллагаатай болгох зэргээр иргэд хилээр саадгүй нэвтэрч зорчих боломжийг бүрдүүлнэ.
- ОХУ, БНХАУ-тай 3 улсын "Эдийн засгийн корридор"-ын хөтөтөлбөр хэрэгжүүлж, Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу хоёр улсын хооронд ажиллах хүч солилцох, Японы томоохон үйлдвэрүүдийн салбарыг Монголд байгуулах, манай улсын байгалийн баялгийг Японы өндөр технологи ашиглан боловсруулах үйлдвэрүүд байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.
- Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн, Монгол Улсыг олон улсын агаарын болон автозам, төмөр замын дамжин өнгөрөх тээврийн зангилаа болгоно. Шинэ онгоцны буудлыг түшиглэн олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бааз байгуулна.
- Гадаад бодлогыг улс төржилтөөс ангид, нэгдмэл байлгах зарчим баримталж, төр, засгийн байгууллагуудын гадаад харилцаанд нэгдсэн зохицуулалт хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН

УХА0122

№ 799

ОН 27

СЭР

ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН

Хүний жам ёсны, заяагдмал эрх, хувийн өмчийг дээдэлсэн, хуулийн засаглалыг тогтооно.

ХУУЛЬ ЗҮЙ

- Төрийн тогтолцоог боловсронгуй болгох үүднээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ард нийтийн санал асуулгын үндсэн дээр шийдвэрлэнэ.
- Сайн засаглалыг хангах үүднээс Төрийн албаны боловсон хүчний тухай хуулийг батлан гаргана. Төрийн албанд мэдлэг боловсролтой боловсон хүчнийг сонгон авах, тогтвортой ажиллуулах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.
- Авлигыг бууруулж, авилгын индексээр дэлхийд эхний 50-д орж урагшилна.
- Эрүүгийн хуульд малын хулгайд ноогдуулах ялын бодлого чангарсныг үргэлжлүүлэн аймаг, дүүрэг дэх төвлөрсөн мал нядлах газруудыг бүрэн камержуулж, цагдаагийн байгууллагын хяналтыг тогтооно.
- Төрийн үйлчилгээг иргэд, бизнесийнхэнд шуурхай, ойлгомжтой хүргэх үүднээс зөвшөөрөл, бүртгэлийн тогтолцоонд үнэлгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхүйн үзүүлэлтээр 76-аас 56-д орсон амжилтаа ахиулж эхний 40-д орно.
- Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Хуулийн байгууллагын ажилтнуудад хариуцлага тооцох механизмыг бий болгоно. Хууль зүйн нэр томъёог жигдлэн цэгцэлж, хуулиудын давхардал, хийдлийг арилгах ажлыг хийж дуусгана.
- Шүүхийн шинэтгэлийн багц хуулиудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулж Монгол Улсын иргэнд Үндсэн хуулиар олгогдсон шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай хангана.
- Мэргэшсэн, чадварлаг хууль сахиулах байгууллагатай байхын тулд цагдаагийн албаны сургалтын шинэ тогтолцоог бүрдүүлнэ. Цагдаагийн албанд ороход урт хугацааны мэргэжлийн сургалтанд хамрагддаг болно.
- Захиргааны үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинээр батлагдсан Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх, улсын хэмжээнд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг цэгцлэнэ.
- Иргэний хууль, эдийн засаг, бизнесийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Улсын Их Хурал болон түүний дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж, УИХ-ын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга батыг сахиулна.
- Төсвийн хуулийг боловсронгуй болгож, Төсвийн төсөл боловсруулах, төсвийн сахилга батыг сайжруулах, төсөв батлах үйл ажиллагаанд шинэ зарчмыг нэвтрүүлнэ.
- Төрийн дээд байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, хийдлийг арилгахын тулд Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулна.
- Шүүхийн шинжилгээний албыг өндөр технологиор шинэчилж, орчин үеийншаардлага хангасан алба болгон өөрчилж, тус албаны мэргэжлийн үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэлийг сэргээнэ.





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.24 № 799
танай _____-ны № _____-т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Ардчилсан намын “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намаас ирүүлсэн “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Ардчилсан намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Ардчилсан намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

000020